

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 03 дугаар сарын 29

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Уул уурхайн сайд /хуучнаар/-ын 2013 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2016 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч /ерөнхий менежер/-тай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, яамны 2016 оны үйл ажиллагааны тайлан, бусад мэдээ материалд тулгуурлан Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 4 багц, 13 үзүүлэлтээр дүгнэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2016 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээ **87,7%** буюу **4,4** оноотой байна.

I. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ.

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн яам /хуучнаар/-ны эрхлэх асуудлаар тусгагдсан 127 арга хэмжээг хяналтанд авч ажилласнаас 2016 оны хагас жилд дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний биелэлт 91,7%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 94,0%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 88,7%, нийт арга хэмжээний биелэлт 90,4%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.

Хагас жилийн үнэлгээний дүнг 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1/1291 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж ажилласан.

**Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл**

2016 оны хагас жил

Бодлогын зорилт	Арга хэмжээний тоо	Биелэлтийн явц /хувь/						Тасарсан	Дүгнэг дээгүй	Биелэлт /хувь/
		100%	90%	70%	50%	30%	10%			
1. Уул уурхайн сайдын дангаар хэрэгжүүлэх										
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	16	8	7	1						93,8
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	2	1			1					75,0
Дүн	18	9	7	1	1					91,7
2. Уул уурхайн сайдын толгойлж хэрэгжүүлэх										
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	19	10	9							95,3
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	6	2	3	1						90,0
ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН	5	4		1						94,0
Дүн	30	16	12	2						94,0
3. Бусад яам, газартай хамтарч хэрэгжүүлэх										
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН.	30	16	7	3	2	1			1	88,6
1. Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	6	3			3					75,0
6. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого	2	2								100,0
7. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх бодлого	2				1				1	50,0
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого	4	2	2							95,0
ХОЁР. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН.	1	1								100,0
ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН	4			1	1				2	60,0
Гадаад харилцаа	2	1		1						85,0
Нийгмийн аюулгүй байдал	4	3			1					87,5
ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН	24	16	5	3						94,2
Дүн	79	44	14	8	8	1			4	88,7
НИЙТ ДҮН	127	69	33	11	9	1			4	90,4

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 105 арга хэмжээ, үүнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 76, хамтран хэрэгжүүлэх 28, оролцогчоор хэрэгжүүлэх 1 арга хэмжээний биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Яамны хэрэгжүүлсэн нийт 105 арга хэмжээнээс Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын 6 арга хэмжээ 14%, Эдийн засгийн тогвортой өсөлтийг хангах бодлогын 85 арга хэмжээ 23,8%, Нийгмийн бодлогын 3, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 11 арга хэмжээ тус бүр 10%, нийт арга хэмжээ 22,4%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.

Яам толгойлон хэрэгжүүлэх 76 арга хэмжээний биелэлтийг 23.0%, хамтран хэрэгжүүлэх 28 арга хэмжээний биелэлтийг 18,3%-тай дүгнэсэн ба үнэлгээний дүнг

яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулан, тайланг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/284 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж ажилласан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл

/2016 жилийн эцэс/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжэний тоо	Хэрэгжилт /%/, арга хэмжээний тоо							Хэрэгжилт /%/ /-/
			100	90	70	50	30	10	/-/	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	4	6					1	4	1	14.0
Хоёр. Эдийн засгийн тогвортой өсөлтийг хангах бодлого	25	85	3	2	1	6	14	47	12	23.8
Гурав. Нийгмийн бодлого	2	3						1	2	10.0
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	5	11						4	7	10.0
Дүн	36	105	3	2	1	6	15	56	22	22.4

1.2. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан 2, 5, 7, 12 дугаар зорилтын 15 арга хэмжээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарч байна.

Эдгээрээс 1 арга хэмжээ /Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх/-нд үнэлгээ өгөөгүй, 4 арга хэмжээ 100%, 4 арга хэмжээ 90%, 6 арга хэмжээ 70%-ийн тус тус биелэлттэй, жилийн эцсийн байдлаар 84,2%-тай дүгнэсэн.

Үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулан тайланг 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/256 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, үнэлгээний дүнг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж ажилласан.

**Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл**

/2016 оны эцэс/

Бодлогын зорилт	Заалтын тоо	Хэрэгжилтийн явц /хувь/								
		100	90	70	50	30	10	0	Үнэлэх боломжгүй	Биелэлт /хувь/
Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	3	1	1	1	-	-	-	-	-	86.6
Зорилт 5. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	5	1	1	2	-	-	-	-	1	82.5
Зорилт 7. Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.	6	1	2	3	-	-	-	-	-	81.6
Зорилт 12. Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.	1	1	-	-	-	-	-	-	-	100.0
Дүн	15	4	4	6	-	-	-	-	1	84,2

1.3. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох эрх зүйн баримт бичгийг агуулгаар нь Геологи, эрдэс баялгийн бодлого, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого, Уул уурхайн бодлого, Хүнд үйлдвэрийн бодлого, Нийтлэг асуудал гэсэн 5 ангиллаар хяналтад авч нийт 289 шийдвэрийн 416 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийв.

Геологи, эрдэс баялгийн бодлогын 23 шийдвэрийн 25 заалтын хэрэгжилт 94.0%, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 37 шийдвэрийн 44 заалтын хэрэгжилт 75.9%, уул уурхайн бодлогын асуудлын 50 шийдвэрийн 56 заалтын хэрэгжилт 78.0%, хүнд үйлдвэрийн бодлогын асуудлын 19 шийдвэрийн 30 заалтын хэрэгжилт 77.6%, нийтлэг асуудлын 160 шийдвэрийн 261 заалтын хэрэгжилт 88.4 хувийн тус тус биелэлттэй байна.

Тогтоол, шийдвэрийн агуулгаар нь ангилж авч үзвэл:

№	Ангилал	Шийдвэр	Заалт	Үнэлгээ /%/
1	Геологи, эрдэс баялгийн бодлого	23	25	94,0
2	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого	37	44	75,9
3	Уул уурхайн бодлого	50	56	78,0
4	Хүнд үйлдвэрийн бодлого	19	30	77,6
5	Нийтлэг асуудлын	160	261	88,4

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний УИХ, Засгийн газрын шийдвэрийн нийт 289 шийдвэрийн 416 заалтыг хяналтад авснаас 16 хуулийн 21 заалт, УИХ-ын 21 тогтоолын 38 заалт, УИХ-ын байнгын хорооны 6 тогтоолын 13 заалт, Ерөнхийлөгчийн 9 зарлигийн 16 заалт, Засгийн газрын 103 тогтоолын 139 заалт,

Ерөнхий сайдын 11 захирамжийн 13 заалт, Засгийн газрын 86 хуралдааны тэмдэглэлийн 125 заалт, ҮАБЗ-ийн 8 зөвлөмжийн 11 заалт, ҮАБЗ-ийн 29 хуралдааны тэмдэглэлийн 36 заалтын хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 86,2%-ийн биелэлттэй байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилт

/2016 оны жилийн эцэс/

Тогтоол шийдвэр		Хяналтанд авсан		Хэрэгжилт /хувь/						0 %	Үнэлгээгүй	Үнэлгээ /хувь/
		Шийдвэр-ийн тоо	Заалтын тоо	100 %	90 %	70 %	50 %	30 %	10 %			
УИХ-ын шийдвэр	МУ-ын хууль	16	21	4	3	4	3	0	0	0	7	78.6
	УИХ-ын тогтоол	21	38	24	1	5	4	1	0	1	2	85.3
	УИХ-ын байнгын хорооны тогтоол	6	13	3	4	1	0	0	0	2	3	73.0
Ерөнхийлөгчийн зарлиг		9	16	14	0	0	0	0	0	2	0	87.5
ЗГ-ын шийдвэр	ЗГ-ын тогтоол	103	139	90	6	6	7	1	1	8	20	86.9
	ЕС-ын захирамж	11	13	9	0	0	0	0	0	0	4	100.0
	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	86	125	92	3	3	5	2	2	8	10	86.2
ҮАБЗ-ийн шийдвэр	ҮАБЗ-ийн зөвлөмж	8	11	4	1	3	1	0	2	0	0	70.0
	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	29	36	7	4	5	10	0	0	1	9	70.7
Ерөнхий дүн		289	416	247	22	27	30	4	5	22	62	86.2

Үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/133 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

1.4. “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичигт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан 4 зорилтын I үе шат /2016-2020 он/-ны биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээг хийв.

Бодлогын баримт бичигт туссан, аж үйлдвэрийн салбар, химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилтын хүрээнд алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, газрын тосны үйлдвэр байгуулах төсөл, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх талаар УИХ, ЗГ-ын холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан, Ажлын хэсгийг байгуулсан, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компанийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарласан зэрэг ажлын гүйцэтгэлд 40%,

Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилтын хэрэгжилтэд 40%, геологийн салбарын хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулах ажил 100% хийгдсэн, 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 34,6%-д гүйцэтгэх ажлын биелэлтэд 90%, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын биелэлтэд 30%, хэрэгжилтийн дундаж 50,0%-ийн биелэлттэй дүгнэсэн.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийн биелэлтэд
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл
I үе шат /2016-2020 он/

/2016 оны эцэс/

Зорилт	Үнэлгээ
2.1.3.Аж үйлдвэрийн салбар	
Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.	40
Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.	40
2.1.4.Эрдэс баялгийн салбар	
Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.	90
Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.	30
Хэрэгжилтийн дундаж	50,0

1.5. УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

- а) Зээл, буцалтгүй тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн 2016 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт:

БНСУ-ын КИГАМ-аас санхүүжигдэж байгаа “Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх” төсөл 90,0%, “Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структуурууд ба металлогени” олон улсын төсөл 100,0%, Швейцарийн Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Тогтвортой бичил уурхай” төсөл 100,0%, Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS) 90 хувьтай, Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/ 90%, “Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл” (СЕСМИМ) 90%-ийн хэрэгжилттэй байна.

Канад улсын санхүүгийн жил 04 сарын 01-ээс эхэлдэгтэй холбоотойгоор салбарт хэрэгжиж буй “Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах” (MERIT) төслийн тайлан ирүүлээгүй тул үнэлгээ өгөөгүй болно.

Зээл тусламж болон хамтарсан төслүүдийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **93,3%**-тай байна.

Төслүүдийн хэрэгжилтийн явц

/2016 оны эцэс/

Төслүүдийн нэр	Эрх зүйн үндэслэл /Гэрээ, санамж бичиг, шийдвэр /тогтоол, тушаал/, огноо/	Хэрэгжүүлэх хугацаа /оноор/	Санхүүжилт ийн эх үүсвэр	Хийсэн ажлын явц /ХШҮДАГ/	Тайлбар
Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх Цогтцэций-50 төсөл.	Монгол Улсын Ашигт малтмалын газар, БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялагийн хүрээлэн /КИГАМ/ хооронд байгуулсан санамж бичиг 2010.03.31	2016.07.8-2016.11.31	Кигам (БНСУ-ын төсөв)	90%	2016 онд тус төслийн зорилтуудын хүрээнд геологи, геоморфологи, гидрогеологи, геозкологийн зурагууд 1:100 000-ны масштабтай зураг анхдагч байдлаар зохиогдож, бичвэрийн ажил хийгдсэн боловч дээж сорьцуудын шинжилгээний хариу удааширч байгаа нь суурин боловсруулалтын шатыг хоцрогдуулсан талаар дурьджээ. 2017 оны хээрийн ажлын талбайн санал бэлтгэх, өмнөх судлаачдын материалиас үндэслэн төлөвлөх, 2016 онд талбайн хэмжээнд авагдсан дээж сорьцуудыг лабораторит шилжүүлэх зэрэг ажлууд хүлээгдэж байна.
“Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах” (MERIT)	2016 оны 5-р сарын 25-нд батлагдсан Ашигт Малтмал Газрын Тосны Газрын (АМГТГ) Чадавхи хөгжүүлэх төлөвлөгөө	2016-2022	Буцалтгүй тусламж	/-/	MERIT төслийн хүрээнд “Газрын тосны хайгуул ба бүтээгдэхүүн хуваах гэрээ” сэдвээр нийт 49 албан хаагчдад хийсэн танилцуулга, “Канадын газрын тосны салбарын хууль эрх зүйн орчин, салбарын үйл ажиллагааны зохицуулалт” сэдвээр танилцуулга Канадын Спрол буюу Дэлхийн Газрын Тосны Зөвлөх байгууллагатай хамтран АМГТГ-ын удирдах ажилтнуудад “Байгалийн нөөц баялгийн удирдамж ба хууль дүрэм” сэдвээр цахим сургалтуудыг тус тус зохион байгуулсан гэсэн боловч тус төслийн нэгжээс 2016 оны үйл ажиллагааны тайлангаа ирүүлээгүй тул үнэлгээ өгөх боломжгүй байна.
Хойд-Төв-Зүүн Азийн 3-н хэмжээст геологийн струк-	Монгол, ОХУ, БНХАУ, Казакстан улсуудын	2010-2020	Улсын төсөв	100%	Тус төслийн 1 дүгээр зорилтын хүрээнд Монгол орны хэмжээнд аккрец-коллизийн тектоникийн зургийн анхны хувилбарыг

туурууд ба метал-логени ОУ-ын төсөл	хооронд байгуулсан гэрээгээр				1:3000 000 масштабтайгаар зохион, тоон мэдээлэлд урьдчилсан байдлаар оруулсан, 2-р зорилтын хүрээнд Монгол орны хэмжээнд Мезозойн тектоникийн зургийн анхны хувилбарыг шинээр цуглуулсан мэдээллүүдэд тулгуурлан дахин засварлан зурагт нэмэлт оруулж эцсийн хувилбараар зохиож дуусгах ажил, 3-р зорилтын хүрээнд Металлогений эцсийн зураг агуулга болон легендийн хувьд ямар байх, 4-р зорилтын хүрээнд геохимийн сорьцын шинжилгээний үр дүнг нэгтгэн геохимийн сарнилын зураг гаргах 5-р зорилтын хүрээнд геофизикийн судалгаанууд хийгдэж мэдээллийн сан үүсгэн ажилласан байна. Уг төслийн хэмжээнд тайлант онд төлөвлөсөн зорилтуудаа зохих хэмжээнд гүйцэтгэсэн байна.
Тогтвортой бичил уурхай төсөл	МУ-ын Уул уурхайн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн (ШХА) хооронд 2011 оны 3 сарын 28-ны өдөр байгуулсан Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжүүлэх тухай гэрээ	I үе шат 2005-2006 II үе шат 2007-2010 III үе шат 2011-2014 IV үе шат 2015-2018	Буцалтгүй тусламж	100%	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны хувиараа ашигт малтмал олборлогчдын зохион байгуулалтанд оруулах, бичил уурхайчдын аюул, осолгүй, байгаль орчны, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. Бичил уурхайчдыг орлогын өөр эх үүсвэртэй болгох зорилгоор бичил уурхайчдын бизнес эрхлэх санал санаачлагыг дэмжиж 17 жижиг төслийг санхүүжүүлсэн. Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах талаар Монголбанк, Үнэт металлын сорьцын хяналтын газар, Татварын ерөнхий газар, орон нутгийн удирдлагууд, бичил уурхайчид зэрэг холбогдох талуудтай хамтарч ажилласан. Бичил уурхайн мэдлэгийн төвийг байгуулах талаар бодлогын хэлэлцүүлэг хийж веб платформ бий болгох ажлыг мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байна.
Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл (СЕСМИМ)		2016-2020 (4 жил)	Канадын засгийн газрын тусламж	90%	СЕСМИМ төслийн 2016 оны гүйцэтгэх ажлын хүрээнд Канадын Алберта мужид “Strategic management: Energy and Finance” 14 хоногийн сургалт, “Уурхайн хаалт-нийгмийн лиценз 2016” бага

					хурал, Олон улсын шилдэг туршлагын семинар, Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр семинар, “Discover Mongolia” хурлын үеээр “Стратегийн орлогын менежмент” семинар зохион байгуулж, Байгаль орчны аудит /БОНБУ, Уурхайн хаалт, Орлогын менежмент, Тусгай зөвшөөрөл, Кадастрын ажлын хэсгүүдийг байгуулж анхны хурлуудыг хийсэн. Тус төслийн хүрээнд туршлага судлах аялал, сургалтанд холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан байна.
Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /AMEP/	- 2015 оны 2-р сарын 5-ны өдөр Монгол Улсын Засгийн газар (Сангийн Яам) болон Австрали Улсын Засгийн газрын (Гадаад Харилцаа, Худалдааны Яам) хооронд байгуулсан дэд гэрээ -2016 оны 11-р сарын 25-ны өдөр Монгол Улсын Засгийн газар (Сангийн Яам) болон Австрали Улсын Засгийн газрын (Монгол Улс дахь Австрали Улсын Элчин сайдын Яам) хооронд байгуулсан дэд гэрээ	2015-2018 /3 жил/	Австрали Улсын Засгийн Газар, Гадаад Харилцаа, Худалдааны Яам	90%	Монгол Улсад Үндэсний Геологийн алба байгуулахад техникийн туслалцаа үзүүлэх зорилтын хүрээнд геологийн алба байгуулахад үзүүлэх техникийн туслалцааг тодорхойлох нөхцөл байдлын судалгаа, бүтэц загварын харьцуулсан судалгаа, эрх зүйн орчны судалгааны ажлуудыг гүйцэтгэж холбогдох зөвлөмжүүдийг УУХҮЯ, АМГТГ-т өгч ажилласан байна. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, Уул уурхайн сургуультай хамтран ашигт малтмал баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулсан. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Олон улсын түвшинд болон Монгол Улсад ашигт малтмалын үнэлгээ хийж буй код, аргачлалын талаарх судалгааны тайланг гаргасан байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 300 аж ахуйн нэгжийн 500 гаруй ажилтанд хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг АМГТГ-ын цахим тайлангийн систем ашиглан хүргүүлэх тухай сургалтыг зохион байгуулсан.

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)		2011-2016 (5 жил)	Дэлхийн Банк – Зээлийн дугаар 4888-MN, Тусламжийн дугаар TF 16382	90%	Тус төслийн Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилтын хүрээнд “Багануур ХК-ний өргөтгөл шинэтгэлийн ажлын ТЭЗҮ хийх сонгон шалгаруулалт” “Дархан-Сэлэнгийн төвийн бүсэд Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах ТЭЗҮ боловсруулах”, “Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах” ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэн ажлын хэрэгжилтэд хяналт тавин хүлээн авах, ТЭЗҮ боловсруулах ажлуудын Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ болон уурхайн бүсэд Хуримтлагдах Нөлөөллийн Үнэлгээ хийх зөвлөх компаниудийг сонгон шалгаруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэж эдгээр ажлуудын ТЭЗҮ болон БОННУ-ний тайланг 2017 оны 7 сард хүлээн авахаар ажиллаж байна.
Хэрэгжилтийн дундаж					93,3%

- b) Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1:50000, 1:200000-ны масштабын зураглалын болон сэдэвчилсэн судалгааны ажлууд 84,8%-ийн хэрэгжилттэй байна.

Тайлант онд суурин болон хээрийн судалгааны ажилтай 23 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Шинээр хэрэгжүүлэх 10 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлснээр нутаг дэвсгэрийн 5%-д төсөл хэрэгжих боломж бүрдсэн. 2017 онд нутаг дэвсгэрийн 1.5%-д төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан байна.

Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 86%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2016 онд УГЗ-200-Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V, Төв Монгол-VI төслүүдийн суурин боловсруулалтын ажлыг хэрэгжүүлж дууссан. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авснаар 100% хамрагдаж дуусна. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг “К” хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.

Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутгийн өмнөд хэсгүүдийг хамарсан талбайд агаарын геофизикийн 5-н сувгийн Алтай-1, Алтай-2 төслүүдийн хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлж дууссан. Төслүүдийн хээрийн судалгааны анхдагч материалыг хүлээн авсан. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13% хамрагдана.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Монгол орны баруун хэсэгт ашигт малтмалын томоохон орд олох зорилгоор Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудын нутгийн хэмжээнд Баруун Монголын цул сульфид-2013 төслийг хэрэгжүүлж эцсийн суурин боловсруулалтын ажилтай танилцаж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан. Сансрын зургийн тайлалт, Газрын ховор элементийн металлогени, Монгол орны металлогени зэрэг төслүүдийн суурин боловсруулалтын ажлууд хийгдсэн.

Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авна. Геологийн судалгааны ажилд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, ОУ-ын хэмжээнд хүргэх зорилгоор ASTER төрлийн хиймэл дагуулын мэдээллийг боловсруулах Сансрын зургийн тайлалт-2013 төслийн суурин боловсруулалт, Геомэдээллийн сан-2013 төсөл геологийн 1:500000, геоморфологийн 1:1000000, гидрогеологийн 1:500000-ны масштабын зургийг нэгтгэх, хээрийн судалгааны ажлын анхдагч материал цэгцлэн бүртгэлжүүлэх төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авах бэлтгэл ажлыг ханган суурин боловсруулалтын түвшинд хүргэж ажиллажээ.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологийн судалгааны ажлын явц

/2016 оны жилийн эцэс/

Төслүүдийн нэр	Эрх зүйн үндэслэл /Гэрээ, санамж бичиг, шийдвэр /тогтоол, тушаал/, огноо/	Хэрэгжүүлэх хугацаа /оноор/	Санхүүжилтийн эх үүсвэр	Хийсэн ажлын явц %	Тайлбар
Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн судалгааны ажил	Уул уурхайн сайдын 2014 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 48 дугаар тушаал	2012-2018	Улсын төсөв	84,8	2016 онд 1:50000 масштабын судалгааны нийт 23 төсөл үргэлжлэн хэрэгжсэн. 1:200000 масштабын зураглалын 4 төсөл хэрэгжиж дууссан. Сэдэвчилсэн судалгааны 6 төсөл үргэлжлэн хэрэгжиж байна.

Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтийн нийт дундаж 2016 оны жилийн эцсээр **89,1%**-тай байна.

II. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

2.1. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон түүний биелэлтийг дүгнэх журам”-ын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас Төсвийн шууд захирагч /Төрийн нарийн бичгийн дарга/-тай байгуулсан 2016 оны Үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан 2016 оны Үр дүнгийн гэрээний биелэлт **96,6** оноогоор дүгнэж, Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг “А” буюу “Маш сайн” үнэлсэн.

Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээ

/2016 оны жилийн эцэс/

Арга хэмжээний нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Төлөвлөгөөний биелэлт, хувь							Дүгнэгдээгүй	Биелэлт %-аар/	Оноо
		100%	90 %	70 %	50 %	30 %	10 %	0%			
Нийт бүтээгдэхүүн нийлүүлэлт	86	28	29	13	11	2	1		2	83,8	27,2
Тусгай захиалгат бүтээгдэхүүн нийлүүлэлт	46	19	15	9	2	1				94,6	39,4
Мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилт	4	4								100,0	30,0
Дүн	136	51	44	22	13	3	1		2	92,8	96,6

Төсвийн ерөнхийлөн захирагч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Төсвийн шууд захирагч, Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал нарын байгуулсан 2016 оны Үр дүнгийн гэрээний хавсралт, яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийтдээ 136 ажил үйлчилгээ, төлөвлөгдсөн ба эдгээрээс дараах 2 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно. Үүнд:

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ:

1.4.1.2. Салбарын болон салбарын төрийн өмчит компаниудын эдийн засгийн мэдээлэл, техник эдийн засгийн үзүүлэлтийн зорилтот түвшинд суурилсан судалгаа, шинжилгээнүүдийг хийж, яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж, салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэл, аргачлалыг сайжруулахад дэмжлэг үзүүлж бодлогын удирдамжаар ханган ажиллах,

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн өмчит компаниудын хагас жилийн болон жилийн эцсийн тайланг шалган хүлээн авч, удирдлагад танилцуулан шаардлагатай мэдээлэл, тооцоогоор хангаж ажиллана.

Тоо хэмжээ: 2 удаа, Чанар: Хагас жил болон жилийн эцсийн тайланг шалгаж хүлээн авсан байна. Хугацаа: 12 дугаар сард

БИЕЛЭЛТ: Салбарын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн төлөвлөлт, мэдээ тайлан гаргахад шаардлагатай мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, холбогдох байгууллагуудаас тогтмол авах саналыг хүргүүлсэн.

1.4.2.2. Сайд (ТЭЗ)-ын төсвийн багцын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн баталгаажуулж дүнг ТЭЗ (сайд)-д танилцуулан хуулийн дагуу холбогдох газруудад хүргүүлнэ.

- Сайдын багцын харьяа байгууллага, төслүүдийн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шалгаж хүлээн авна.

- Сайдын багцын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг "Plastic" программд нэгтгэн Сайдын багцын нэгдсэн санхүүгийн тайланг гаргаж, удирдлагад танилцуулан, баталгаажуулна.

Тоо хэмжээ: 2 удаа, Чанар: Хуулийн хугацаанд нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн байна. Хугацаа: Хагас бүтэн жилээр

БИЕЛЭЛТ: Тайланг оны 4 болон 8 дугаар сард авдаг. Хугацаа болоогүй.

10%-ийн биелэлттэй 1 ажил үйлчилгээ:

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ:

6.4.1. Геологи, уул уурхайн салбараас улсын төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх, эрдсийн бүтээгдэхүүний үнэ, эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийнэ.

- Уурхай, үйлдвэрүүдийн эрдэст бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийж зөвлөмж, дүгнэлт гаргана.

- Уул уурхайн боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн талаар санал боловсруулна.

- Уул уурхайн гаралтай эрдэс, түүхий эд, баяжмал бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ тогтоох судалгаа хийж, дүгнэлт гаргана.

Тоо хэмжээ: 1 удааа, Чанар: Санал зөвлөмж гарсан байна. Хугацаа: 4 улиралд

БИЕЛЭЛТ:

Сангийн яам, Татварын ерөнхий газар, АМГТГ-аас ирүүлсэн мэдээ тайланг нэгтгэн, яамны бодлогын газруудыг тоон мэдээллээр ханган ажиллаж байна. Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн бүртгэлийн ажлыг яамны бусад газруудтай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна. Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 10 сарын 24-ний өдрийн хамтарсан 358/А45 тоот тушаалаар батлагдсан байнгын ажиллагаатай Ажлын хэсэгт ажиллаж байна.

30%-ийн биелэлттэй 3 ажил үйлчилгээ:

НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ:

5.1.3. Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль болон Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн заалтыг хэрэгжүүлэх.

- Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмыг шинэчлэн батлуулж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна.

Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Журам батлагдсан байна. Хугацаа: 12 сард

БИЕЛЭЛТ. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах журмыг боловсруулсан.

5.1.4. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн орчныг сайжруулах.

- “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсан байна.

Хугацаа: 12 сард

БИЕЛЭЛТ:

Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, паркийн нэгжүүдийн үйлдвэрлэлийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг боловсруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэв. Үүнд:

1. Эрдэнэт, Дархан, Багануур, Баянговь үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагуудаас хуулийн төсөлд санал авч, нэгтгэв.

2. 2016 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 16-ны хооронд БНХАУ-ын хилийн чанад дахь аж үйлдвэрийн паркийн туршлагатай танилцаж, холбогдох судалгааг хийв.

3. БНХАУ-ын аж үйлдвэрийн паркийг хөгжүүлсэн туршлага болон судалгааны талаар 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр яамны ажилтнууд болон ҮТП-ийн удирдлагуудыг хамруулсан танилцуулга, нээлттэй хэлэлцүүлгийг хийв.

4. 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хуулийн үзэл баримтлал болон төслийн анхны хэлэлцүүлгийг Паркийн удирдлагууд болон зарим төрийн бус байгууллагын хүрээнд зохион байгуулсан.

ТУСГАЙ ЗАХИАЛГАТ АРГА ХЭМЖЭЭНИЙ:

5.1.2. Үйлдвэрлэл эрхлэгчдэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх

- Бүрэн задаргаатай иж бүрдэл /СК/У, хагас задаргаатай иж бүрдэл /ЗК/У угсрах үйлдвэрлэлийн менежментээр үйлдвэрлэх бараа, бүтээгдэхүүний эд анги, сэлбэгийн иж бүрдлийн багцын кодыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д бий болгож,

үйлдвэрлэлд шаардлагатай сэлбэг, эд анги, материалын иж бүрдлийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх" тухай хуулийн төсөл боловсруулж батлуулна.

- Гааль ба НӨАТ-аас чөлөөлүүлэх газрын тос боловсруулах, шатдаг занар болон нүүрснээс хий шингэн түлш үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна.

Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. Хугацаа: 12 сард

БИЕЛЭЛТ:

Машин байгууламжийн үйлдвэрлэлийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор автобус, автомашин, цахилгаан машин, хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, чиргүүл, машин, механизмыг угсрах зориулалтаар Монгол улсад үйлдвэрлэдэггүй эд ангийг хагас иж бүрдлийн нөхцөлөөр импортлоход "Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл"-ийг боловсруулж байна. Үүнд:

1. Хуулийн төслийг боловсруулж газар, хэлтсүүдээс санал авсан.

2. Сангийн яам, ХЗДХЯ-наас санал ирсэн.

3. Яамдаас ирсэн саналуудыг нэгтгэж, Засгийн газраар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

2.2. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2016 онд 7 стратеги зорилтын хүрээнд нийт 370 арга хэмжээ /ажил үйлчилгээ/ төлөвлөж хэрэгжүүлснээс төлөвлөгөөний биелэлт, хүрсэн түвшинд хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл 92,8%-тай байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Стратегийн зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ %
Стратегийн зорилт 1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;	100	91,8
Стратегийн зорилт 2. Геологийн талаарх хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;	65	91,9
Стратегийн зорилт 3. Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;	30	92,0
Стратегийн зорилт 4. Түлш, газрын тосны салбарын хууль, тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;	43	92,6
Стратегийн зорилт 5. Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;	23	93,7
Стратегийн зорилт 6. Хууль тогтоомж, бодлогын дүн шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;	71	92,4
Стратегийн зорилт 7. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах;	38	91,5
Дундаж үнэлгээ	370	92,8

2.4. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан, Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын 55-д аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан тухайн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг гаргаж 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ гэж заасны дагуу гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний үнэлгээг нэгдсэн тайланд нэгтгэлээ.

Аймгийн Засаг дарга нартай 2016 онд хамтран ажиллах гэрээг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан.

Нийт 16 аймгийн Засаг дарга гэрээний биелэлт ирүүлсэн бөгөөд гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хийж гүйцэтгэв. Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Хөвсгөл аймгуудаас хамтран ажиллах гэрээний биелэлтийг баталгаажуулж ирүүлээгүй тул "0" хувийн биелэлттэй дүгнэсэн болно.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **65.5** хувьтай.

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт

/2016 оны жилийн эцэс/

№	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувь							Үнэлээгүй	Биелэлт, %
					100	90	70	50	30	10	0		
1	Архангай	Д.Бат-Эрдэнэ	1	11	5	1	1	-	-	-	-	3	94.3
2	Баян-Өлгий	Х.Дармен	2	11	6	1	-	1	-	-	-	2	92.5
3	Баянхонгор	Д.Жаргалсайхан	3	11	7	1	2	-	-	-	-	1	93.0
4	Булган	Д.Эрдэнэбат	4	11									0
5	Говь-Алтай	О.Амгаланбаатар	5	11									0
6	Говьсүмбэр	Л.Одсэр	6	11	2	7	4	-	-	-	-	4	85.4
7	Дархан-Уул	А.Энхболд	7	11	4	2	1	1	-	-	-	-	87.5
8	Дорноговь	П.Ганхуяг	8	11									0
9	Дорнод	М.Бадамсүрэн	9	11									0
10	Дундговь	С.Од-Эрдэнэ	10	11	3	4	2	-	-	-	-	2	88.9
11	Завхан	Ж.Жамъянтив	11	11	5	2	2	-	-	-	-	2	91.1
12	Орхон	С.Дангаасүрэн	12	11	3	3	1	1	-	-	-	3	86.3
13	Өвөрхангай	Д.Тогтохсүрэн	13	11	4	3	2	-	-	-	-	1	90.0
14	Өмнөговь	Б.Бадраа	14	11	3	5	1	2	-	-	-	-	79.1
15	Сүхбаатар	Ж.Батсуурь	15	11	6	1	1	1	-	-	1	1	81.0
16	Сэлэнгэ	С.Бүрэнбат	16	11	4	4	-	2	-	-	-	1	86.0
17	Төв	Д.Баярбат	17	11	5	2	1	-	-	-	1	2	83.3
18	Увс	Д.Цэндсүрэн	18	11	1	3	1	1	-	-	-	-	81.6
19	Ховд	Д.Цэвээнравдан	19	11	4	4	-	-	-	-	1	2	84.4
20	Хөвсгөл	А.Эрдэнэбаатар	20	11									0
21	Хэнтий	Ж.Оюунбаатар	21	11	2	1	2	-	-	-	1	4	71.6
НИЙТ												65.5	

2.5. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 100%, худалдан авах ажиллагааны биелэлт 94,4%, 2016 оны жилийн эцсийн хэрэгжилт 97,2%-ийн биелэлттэй дүгнэв.

Хөрөнгө оруулалтын талаар:

Замын-Үүдийн Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийн автоматжуулалт төслийн үлдэгдэл санхүүжилтийг 2016 онд хийгдэх хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөгдсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

Улсын төсвийн хөрөнгөөр 2016 оны III дугаар улирлын байдлаар 13,395.86 сая төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авахаар гэрээ байгуулснаас тухайн онд санхүүжүүлэх нь 2,200.25 сая төгрөг байна. Бүрэн хэрэгжсэн 100 хувьтай 10, 50 хувийн хэрэгжилттэй 1, дүгнэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ байна.

Зээл тусламжийн хөрөнгөөр:

Зээл тусламжийн хөрөнгөөр 145.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн нь 100 хувийн хэрэгжилттэй байна.

Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр:

Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөгчийг дэмжих сангаас 1,440.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 100 хувьтай 3, 90 хувийн хэрэгжилттэй 1, 70 хувийн хэрэгжилттэй 1, дүгнэх боломжгүй 1 төсөл, арга хэмжээ байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

III. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг үндэслэн хийлээ. 2016 оны жилийн эцсийн байдлаар Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт 100,0%, Хүний нөөцийн бодлогын ил тод байдлын шалгуур үзүүлэлт 88,6%-ийн тус тус биелэлттэй, ерөнхий дундаж 95,3%-ийн биелэлттэй дүгнэлээ.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

**Байгууллагын ил тод байдлыг илтгэх
шалгуур үзүүлэлтэд өгсөн үнэлгээ**

/2016 оны эцэс/

Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Үнэлгээ
Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	10	100,0
Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	7	88,6
Ерөнхий үнэлгээ	17	95,3

3.2. БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИННИЙ ҮНЭЛГЭЭ.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын "Найм"-ын 61-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газар/АТГ/-аас гаргаж ирүүлдэг. 2016 онд АТГ-аас төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ хийгдээгүй байна. Иймд яамны 2016 оны үйл ажиллагааны үнэлгээнд оруулаагүй болно.

IV. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВАРЫН ҮНЭЛГЭЭ

4.1. ЗАСАГЛАЛЫН БОЛОН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

"Үзүүлэлт батлах тухай" Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар яамны засаглалын 13 үзүүлэлт батлагдсанаас Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн ил тод байдал, худалдан авах ажиллагааны үзүүлэлтэд үнэлгээ хийгээгүй, бусад 7 үзүүлэлтийн 2016 оны биелэлтэд үнэлгээг хийв.

1. 2016 онд Уул уурхайн сайд /хуучнаар/-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх төлөвлөгөөг яамны дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн сайдын 2016 оны А/44 дугаар тушаалаар батлуулж төлөвлөгөөний дагуу сайдын А/63 тоот тушаалаар Геологийн төв лаборатори /ГТЛ/, Геологийн судалгааны төв /ГСТ/, яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийж тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлж ажилласан байна.

2. Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ-2016 онд АТГ-аас үнэлгээ хийгдээгүй байна.

3. Уул уурхайн тухай хуулийн үзэл баримтлалыг 2017 оны 1 дүгээр сард Хууль зүй, Дотоод хэргийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хамтран баталсан. Уул уурхайн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, эрдэмтэд, мэргэжлийн багш нарын санал, СЕСМИМ төслийн зөвлөхүүдийн зөвлөмжийг авч тусган Канадын ЭСЯ, Нээлттэй нийгэм форумаас зохион байгуулсан уулзалтын үеэр хуулийн төслийг танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлэн мэргэжлийн холбоодтой хамтарсан ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/113 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

"Алт-2" хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд Монголын Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, алт олборлогч томоохон аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалтыг 2 удаа зохион байгуулж, хөтөлбөрийн төсөлд санал авч тусган, Засгийн газрын 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн, шинжээчийн хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 23 дугаар тушаалаар батлуулсан.

Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам, Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага, Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам, Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Газрын тосны бүртгэл, тооцооны журам, Газрын тосны сургалтын сангийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төсөлд салбарын гадны зөвлөх, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн саналыг авч тусган сайдын тушаалаар батлуулахад бэлэн болгоод байна.

“Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслүүдийг боловсруулан яамны веб сайтад 30 хоногийн турш байршуулан санал авч 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах журмын төсөл, Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам, “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам”-ын төсөлд мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн саналыг авч тусгаж ажилласан байна.

4. Орон нутгаас ирүүлсэн нийт 71 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэн хариуг хүргүүлж ажилласан нь яаманд ирүүлсэн нийт албан бичгийн тоонд 1,51%-ийг эзэлж байна.

5. Иргэдээс яам, агентлагт хандаж гаргасан 279 өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгч ажилласан байна.

6. Газрын тосны тухай хуулийн 8.1.10 дахь заалт /газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох;/-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Уул уурхайн сайдын 2016 оны А/37, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 29 дүгээр тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох” журмыг тус тус баталж газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Газрын тосны мэргэжилтнүүдэд мэргэжлийн зэрэг олгох сургалтын төвөөр 2 удаа гүйцэтгүүлж мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг нийт 46 мэргэжилтэнд олгож ажиллажээ.

Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/113 дугаар тушаалаар геологийн салбарын бодлого, эрх зүйн судалгаа, шинжилгээ хийх үүрэг бүхий төслийн нэгжийг байгуулан тайланг авч ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдсэн худалдан авах ажиллагаагаар нийт 15 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан бараа худалдан авч, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолоор баталсан дүрмийг тус тус үндэслэн жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийг Уул уурхайн яам /хуучнаар/-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/20 дугаар тушаалаар байгуулж хариуцсан ажилтныг томилон ажиллажээ. Яамдын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан дээрх тушаалыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар яамны Засаглалын үзүүлэлтийн ерөнхий үнэлгээ 98,7%-тай, харгалзах 4,93 оноогоор дүгнэсэн.

Засаглалын үзүүлэлт

/2016 оны жилийн эцэс/

№	ҮЗҮҮЛЭЛТ		2016 он	Үнэлгээ	
				Хувь	Оноо
1	Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	3	100	5
		Аудитын зөвлөмжийн хэрэгжилт хувь	16	100	5
2	Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ (АТГ-ын үнэлгээ)		/-/	/-/	/-/
3	Иргэд аж ахуйн нэгжийн саналт хүсэлт гаргасан бодлогын баримт бичиг эрх зүйн акт шийдвэрийн тоо		12	100	5
4	Орон нутгаас ирүүлсэн албан бичгийг шийдвэрлэсэн хариу өгсөн байдал (нийт албан бичгийн тоонд эзлэх %)		1.51	100	5
5	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын бодит шийдвэрлэлт (нийт өргөдөл гомдлын тоонд эзлэх %)		279	100	5
6	Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагаас хувийн хэвшил, төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тоо		18	100	5
7	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн шаардлагын хэрэгжилт	Хариуцсан албан хаагчтай эсэх, төлөвлөгөөт арга хэмжээний биелэлт /%/	100	100	5
		Төрийн захиргааны удирдах албан тушаал дахь хүйсийн зохистой харьцаа хангагдсан эсэх (30%)	27	90	4.5
Дундаж				98,7	4.93

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад яаманд хамаарах геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт зэрэг үзүүлэлтүүдийг баталсан.

2016 онд голлох эрдэс түүхий эд газрын тосны олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл, газрын тос, нүүрс, зэсийн баяжмалын экспорт тус тус өссөн, алтны олборлолт 31,4%, экспорт 64%, төмрийн хүдрийн олборлолт 82,2%, экспорт 93,6%-ийн гүйцэтгэлтэй байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын зорилтот түвшин 2016 онд 1,7 сая.тонн байсан боловч 1,22 сая.тонныг импортолсон нь 71,7%-тай, үүнээс ОХУ-аас 1,16 сая.тонныг импортолсон нь нийт импортын 95%-ийг, бусад улсаас 0,06 сая.тонныг импортолсон нь 4,9%-ийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл ОХУ-аас импортолсон бүтээгдэхүүний хэмжээ нийт импортод буураагүй байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн ерөнхий үнэлгээ 87,7%-тай, харгалзах 4,38 оноогоор, засаглал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт ерөнхий дүнгээр 93,2%, 4,66 оноогоор дүгнэсэн.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

/2016 оны жилийн эцэс/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Суурь үзүүлэлт /2012/	Эхний жил /2013/	2 дахь жил /2014/	3 дахь жил /2015/	4 дэх жил /2016/			Үнэлгээ	
			Зорилтот түвшин	Зорилтот түвшин	Зорилтот түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Хувь	Оноо
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн	29.1	29.7	33	36	40	40.5	0.5	100	5

	1:50000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)										
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг зохиох төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	55.8	57	87	92	100	100	0	100	5.0	
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ	Газрын тос (мянган баррель)	2700	3912	4852	5849	6945	8249	1304	100	5
		Нүүрс (сая тонн)	31.1	31.9	40	50	60	35.4	-24.6	59	3.0
		Зэсийн баяжмал (мянган тонн)	574.3	670	710	800	900	1.445	545	100	5
		Төмрийн хүдэр (сая тонн)	5.2	4.5	5	5.5	6	4.936	-1.064	82.2	4.1
		Алт (тонн)	5	8	30	30	30	18.435	-11.565	61.4	3.07
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ	Газрын тос (мянган баррель)	2600	3030.3	4852	5800	6800	8015	1215	100	5
		Нүүрс (сая тонн)	21.5	20.47	25	33	40	51521	11.521	100	5
		Зэсийн баяжмал (мянган тонн)	500	500	900	1100	1400	1562	162	100	5
		Төмрийн хүдэр (сая тонн)	5	5	5.5	6	6.5	6.084	-0.416	93.6	4.68
		Алт (тонн)	5	8	30	30	30	19.2	-10.8	64	3.2
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (сая тонн)	1.06	1.08	1.2	1.5	1.7	1.22	-0.48	71.7	3.58	
	Үүнээс:										
	ОХУ-аас (нийт импортын хэмжээнд эзлэх хэмжээ буурсан байх)	1.04	0.824	0.722.4		1.02	1.16	0.14	13.7	0.68	
	Бусад улсаас (нийт импортын хэмжээнд эзлэх хэмжээ өссөн байх)	0.15	0.258.4	0.360.0 (A-93)		0.68	0.06	-0.62	9.7	0.48	
6	Газрын тосны хайгуулын талбайд хайгуул, судалгааны ажил хийжээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо	20	20	23	26	26	25	-1	96.1	4.8	
ЭЗНХҮ-ийн ерөнхий үнэлгээ									87,7	4,38	

4.2. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зардал яамны 2016 оны төсөвт суугаагүй тул хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тусгайлсан санал асуулга хийгдээгүй бөгөөд яамны үйл ажиллагааны үнэлгээнд оруулаагүй болно.

V. ДҮГНЭЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2016 онд төлөвлөсөн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт **87,7%**-тай, ерөнхий үнэлгээ **4,4** оноогоор “*сайн*” дүнтэй дүгнэв.

VI. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар нийт 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг яам толгойлон, 28 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй зэрэг бэрхшээл гарч байгааг анхаарч толгойлон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах талаар яамны зүгээс санаачлага гарган ажиллах шаардлагатай;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргахдаа тухайн зорилтын хүрээнд хийгдсэн ажил, явцын мэдээлэл, гарсан шийдвэр, хүрсэн үр дүнгийн түвшинг товч тодорхой, гүйцэд тайлагнах, тухайн тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн арга хэмжээний биелэлт гаргаж ирүүлэх тал дээр нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд онцгой анхаарч ажиллах;
- Хууль тогтоомжийн биелэлтэд тухайн шийдвэр заалтыг хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээний талаар товч, тодорхой биелэлт гаргах, холбогдох тушаал шийдвэрийн огноо дугаар, агуулгыг дурдаж байх, бүрэн хэрэгжсэн гэж үзвэл уг шийдвэр заалтыг хяналтаас хасуулах саналын хамт гаргаж ирүүлж хэвших. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын зүгээс тогтоол шийдвэр хяналтанд авагдсан тухай бүр тэдгээрийг бүх албан хаагчдад хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар:

- Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, гэрээний хавсралт болох яамны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил үйлчилгээний шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, хугацаа, чанар/-ийг оновчтой төлөвлөж, уг ажил үйлчилгээг эзэнжүүлэх, биелэлтийг шалгуур үзүүлэлттэй нь уялдуулан тайлагнах;
- Төлөвлөгөөний биелэлт гаргах талаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах;
- Ажил үйлчилгээний биелэлтийг бичмэл хэлбэрээс гадна зураг, дүрс, график ашиглан тайлагнахад анхаарах шаардлагатай.

Байгууллагын нээлттэй байдлын талаар:

- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ерөнхий агуулгатай гаргаж байгаа тул цаашид шалгуур үзүүлэлт /"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн заалт/-ийг хангах хүрээнд тухайн тайлант жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тоо баримттай, огноо дугаартай тодорхой биелэлт гаргаж байх тал дээр анхаарах шаардлагатай.

Үйл ажиллагааны үр дагаварын талаар:

- Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлт тусгагдсан суурь болон зорилтот түвшний тоон үзүүлэлтийг бодлогын баримт бичгүүдэд тусгасан тоон болон чанарын үзүүлэлттэй уялдуулж төлөвлөх, тухайн тайлант жилд хүрсэн түвшинг үнэн зөв гаргаж байхад бодлогын газрууд анхаарч ажиллах;
- Яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа иргэдийн амьдралд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх Хэрэглэгчийн үнэлгээ /түүвэр судалгаа/ нь яамны үйл ажиллагааны үнэлгээний нэг үзүүлэлт болдог тул мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг 2017 онд хийж гүйцэтгэх шаардлагатай.

VI. ХАВСРАЛТ

- Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны биелэлт,
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт,
- Засаглалын болон эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн үнэлгээний тайланг тус тус хавсаргав.

Хавсралт 44 хуудастай.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР
2017 он